

ТАНИЛЦУУЛГА

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр соёрхон баталсан.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банктai 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээрт "ЭКСИМ банкнаас 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Зээлдэгч болон ЭКСИМ банк хооронд байгуулсан Зээлийн хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгчид 236,000,000 ам.доллар (зөвхөн хоёр зуун гучин зургаан сая ам.доллар) хүртэлх хэмжээний зээлийг олгохоор тохирсон. Дээр дурдсан зээлийн эх үүсвэрийг бүхлээр нь энэ өдөр хүртэл ашиглаагүй байгаа тул энэхүү 700,000,000 ам.долларын Хэлэлцээрт гарын үсэг зурснаар энэхүү 236,000,000 ам.долларын зээлийн эх үүсвэрийг хаасанд тооцно." гэж тусгасан тул Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох хуулийн төслийг боловсрууллаа.

---oOo---